

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/176/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баян-Өлгий аймаг

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 99932710 Цахим хаяг:

jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Х.Манаргүл

Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
5.1 Төлбөрийн акт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
5.2 Албан шаардлага .....	<b>Error! Bookmark not defined.</b>
5.3 Зөвлөмж.....	<b>Error! Bookmark not defined.</b>
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .	<b>Error! Bookmark not defined.</b>

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 <b>БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgii@audit.gov.mn	<b>АЛТАНЦӨГЦ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ С.АВДИКАДИР ТАНАА</b>
2025.02.17 № 52	
танай _____-ны № _____-т	
<b>Өөрчлөлтгүй дүгнэлт</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p> <p><b>Дүгнэлтийн үндэслэл</b></p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p><b>Асуудлыг онцолсон хэсэг</b></p> <p>Тайлант онд онцлох үйл явдал гараагүй байна.</p> <p><b>Аудитын гол асуудал</b></p> <p>Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.</p> <p><b>Бусад асуудлын хэсэг</b></p> <p>Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.</p> <p><b>Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага</b></p>	

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>208,368,291.00</u></b>	<b><u>264,168,459.33</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	97,386,995.00	127,308,526.38
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	97,386,995.00	127,308,526.38
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	97,386,995.00	127,308,526.38
31211	Төрийн сангийн харилцах	97,386,995.00	127,308,526.38
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	8,698,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	8,698,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	102,283,296.00	136,859,932.95
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	229,880.00	312,610.00
35130	Эм боох материал	229,880.00	312,610.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	102,053,416.00	136,547,322.95
35410	Бичиг хэргийн материал	5,655,650.00	5,437,500.00
35420	Аж ахуйн материал	87,984,713.00	118,378,129.00
35440	Түлш, шатах тослох материал	33,000.00	561,000.00
35460	Хүнсний материал	3,975,580.00	3,564,524.00
35470	Бусад хангамжийн материал	4,404,473.00	8,606,169.95
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,624,368,803.19</u></b>	<b><u>5,117,934,651.71</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,624,368,803.19	5,117,934,651.71
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,582,344,516.62	5,076,266,174.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,144,886,060.13	4,982,121,778.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	(134,357,063.34)	(168,415,656.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,410,000.00	2,410,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(2,410,000.00)	(2,410,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	223,090,678.04	324,344,518.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	(127,951,119.20)	(172,738,422.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	115,419,073.00	146,044,273.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(89,059,151.05)	(95,719,391.64)
39209	Зам, гүүрийн байгууламж	869,632.88	869,632.88
39210	Хуримтлагдсан элэгдэл	(434,816.40)	(521,779.68)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	1,390,000,000.00	-
39217	Ном	59,881,222.56	60,281,222.56
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	42,024,286.57	41,668,476.85
39301	Програм хангамж	1,973,239.00	1,973,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(638,952.43)	(994,762.15)
39303	Бусад биет бус хөрөнгө	40,690,000.00	40,690,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,832,737,094.19</u></b>	<b><u>5,382,103,111.04</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,832,737,094.19</u></b>	<b><u>5,382,103,111.04</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,832,737,094.19	5,382,103,111.04

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	537,366,354.00	537,366,354.00
51101	Өмч: - төрийн	537,366,354.00	537,366,354.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,754,807,387.83</b>	<b>3,304,173,404.68</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,754,807,387.83	1,754,807,387.83
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,549,366,016.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,540,563,352.36	1,540,563,352.36
<b>6</b>	<b>ОР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,832,737,094.19</u></b>	<b><u>5,382,103,111.04</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,425,574,711.00</b>	<b>4,234,494,030.95</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,589,094,011.00</b>	<b>1,564,846,430.95</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,589,094,011.00</b>	<b>1,564,846,430.95</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,560,900.00	1,788,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,560,900.00	1,788,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	1,578,149,361.00	1,537,398,118.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	9,383,750.00	25,660,312.95
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,836,480,700.00</b>	<b>2,669,647,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,635,329,700.00</b>	<b>2,376,217,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,635,329,700.00	2,376,217,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>201,151,000.00</b>	<b>293,430,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	201,151,000.00	293,430,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,779,719,165.39</b>	<b>2,685,128,014.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,779,719,165.39</b>	<b>2,685,128,014.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,738,582,187.39</b>	<b>2,613,469,418.27</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,252,804,534.00</b>	<b>1,914,064,592.00</b>
210101	Үндсэн цалин	858,881,527.00	1,206,126,116.00
210102	Нэмэгдэл	342,327,171.00	631,999,476.00
210104	Урамшуулал	51,595,836.00	75,939,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>157,050,217.00</b>	<b>238,697,880.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	108,115,817.00	164,850,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,233,400.00	19,394,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,786,800.00	9,697,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,446,900.00	9,697,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,467,300.00	35,058,580.00

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	199,497,292.00	263,623,904.17
210301	Гэрэл, цахилгаан	4,257,292.00	5,607,044.17
210302	Түлш, халаалт	195,240,000.00	258,016,860.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	39,837,381.00	58,637,242.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,550.00	229,880.00
210502	Хоол, хүнс	39,686,831.00	58,407,362.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	620,000.00
210604	Урсгал засвар	-	620,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,468,950.00	22,381,260.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,560,900.00	1,788,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,908,050.00	20,593,260.62
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	80,923,813.39	115,444,539.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,008,010.00	17,676,880.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,232,740.00	11,818,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,683,063.39	85,948,909.48
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	41,136,978.00	71,658,595.83
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	40,843,270.00	45,880,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,843,270.00	45,880,500.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	293,708.00	25,778,095.83
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	293,708.00	25,778,095.83
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>1,645,855,545.61</u></b>	<b><u>1,549,366,016.85</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>1,645,855,545.61</u></b>	<b><u>1,549,366,016.85</u></b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,838,041,600.00</u></b>	<b><u>2,671,435,600.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,560,900.00</b>	<b>1,788,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,560,900.00	1,788,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,560,900.00	1,788,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,560,900.00	1,788,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,836,480,700.00</b>	<b>2,669,647,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,635,329,700.00	2,376,217,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,635,329,700.00	2,376,217,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	201,151,000.00	293,430,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	201,151,000.00	293,430,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,742,453,212.00</u></b>	<b><u>2,608,095,428.62</u></b>

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,742,453,212.00</b>	<b>2,608,095,428.62</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,700,111,834.00</b>	<b>2,536,831,932.79</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,252,804,534.00	1,914,064,592.00
210101	Үндсэн цалин	858,881,527.00	1,206,126,116.00
210102	Нэмэгдэл	342,327,171.00	631,999,476.00
210104	Урамшуулал	51,595,836.00	75,939,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	157,050,217.00	238,697,880.00
210201	Тэтгэврийн даатгал	108,115,817.00	164,850,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,233,400.00	19,394,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,786,800.00	9,697,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,446,900.00	9,697,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,467,300.00	35,058,580.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	199,757,292.00	266,151,904.17
210301	Гэрэл, цахилгаан	4,417,292.00	7,607,044.17
210302	Түлш, халаалт	195,340,000.00	258,544,860.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	39,650,541.00	58,391,406.00
210502	Хоол, хүнс	39,650,541.00	58,391,406.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,100,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,668,950.00	22,081,260.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,560,900.00	1,788,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,108,050.00	20,293,260.62
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	41,080,300.00	35,944,890.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,386,400.00	23,445,790.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,693,900.00	12,499,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,341,378.00</b>	<b>71,263,495.83</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	42,047,670.00	45,485,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,047,670.00	45,485,400.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	293,708.00	25,778,095.83
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	293,708.00	25,778,095.83
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>95,588,388.00</u></b>	<b><u>63,340,171.38</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>33,101,000.00</b>	<b>33,418,640.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>33,101,000.00</b>	<b>33,418,640.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	33,101,000.00	33,418,640.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,101,000.00	33,418,640.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(33,101,000.00)</u></b>	<b><u>(33,418,640.00)</u></b>

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b> (8)=(3)+(6)+(7)	62,487,388.00	29,921,531.38
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		97,386,995.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		127,308,526.38

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	537,366,354.00	1,540,563,352.36	1,754,807,387.83	3,832,737,094.19
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	537,366,354.00	1,540,563,352.36	1,754,807,387.83	3,832,737,094.19
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	537,366,354.00	1,540,563,352.36	1,754,807,387.83	3,832,737,094.19
D08	Тайлант үеийн үр дүн			1,549,366,016.85	1,549,366,016.85
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	537,366,354.00	1,540,563,352.36	3,304,173,404.68	5,382,103,111.04

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,769,264,400.00	2,613,947,972.79
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,769,264,400.00	2,613,947,972.79
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,715,653,300.00	2,568,462,572.79
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,966,760,200.00	1,914,064,592.00
210101	Үндсэн цалин	1,285,278,900.00	1,206,126,116.00
210102	Нэмэгдэл	604,973,100.00	631,999,476.00
210104	Урамшуулал	76,508,200.00	75,939,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	245,844,900.00	238,697,880.00
210201	Тэтгэврийн даатгал	167,174,500.00	164,850,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,667,600.00	19,394,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,833,800.00	9,697,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,833,800.00	9,697,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	39,335,200.00	35,058,580.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	291,930,000.00	266,151,904.17
210301	Гэрэл, цахилгаан	8,711,000.00	7,607,044.17
210302	Түлш, халаалт	283,219,000.00	258,544,860.00
2105	<b>Нормативт зардал</b>	89,892,500.00	58,391,406.00
210502	Хоол, хүнс	89,892,500.00	58,391,406.00

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	28,718,000.00	20,293,260.62
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,718,000.00	20,293,260.62
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	91,007,700.00	69,363,530.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	78,363,400.00	56,864,430.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,644,300.00	12,499,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	53,611,100.00	45,485,400.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	53,611,100.00	45,485,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,611,100.00	45,485,400.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,671,898,800.00	2,643,869,504.17
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,378,468,800.00	2,376,217,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,378,468,800.00	2,376,217,600.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	293,430,000.00	267,651,904.17
132001	Орон нутгийн төсвөөс	293,430,000.00	267,651,904.17
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		97,386,995.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		127,308,526.38
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	81.00	83.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	52.00	54.00
620003	Үйлчлэх ажилтан	28.00	28.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	450.00	457.00
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	450.00	457.00
630001	Төрийн өмчит ЕБС	450.00	457.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тус байгууллагад нэмэлт данс байхгүй байна

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургууль нь бүрэн дунд боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Сургууль нь 2024 онд “Үнэлгээний үр дүнд суурилан сургуулийн менежментийг сайжруулж, хүн бүр хариуцлагатай ажиллаж, боловсролын үйлчилгээ хүртээмж чанарт ахиц гаргах” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Сурах үйл ажиллагааг дэмжих, багш сурагч эцэг эхийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, боловсролын тухай хуулийг сурталчлах
- Сургах, сургаалтанд шинэ арга зүйг ашиглах, хүн бүр ажилдаа хянамгай байх”

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Боловсролын Ерөнхий хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургууль нь сургуулийн захирлын 2019 оны 13 тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилладаг байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1549.4 сая төгрөгөөр буюу 40.4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	97.4	127.3	29.9
Бараа материал	102.3	136.9	34.6
Үндсэн хөрөнгө	3,624.4	5,117.9	1,493.6
Урьдчилж гарсан зардал	8.7	-	(8.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,832.7</b>	<b>5,382.1</b>	<b>1,549.4</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,832.7	5,382.1	1,549.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,832.7</b>	<b>5,382.1</b>	<b>1,549.4</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос мөнгөн хөрөнгө 127.3 сая төгрөг болж 29.9 сая төгрөгөөр өссөн байна.

Урьдчилж гарсан зардал данс оны эхнээс 8.7 сая төгрөгөөр буурч оны эцэст тооцоогүй гарсан байна. Энэ нь цахим худалдан авалт хийж гэрээ байгуулсан компаниуд 2023 онд 8.7 сая төгрөгийн бараа үйлчилгээг гэрээний хугацаанд нийлүүлээгүйтэй холбоотой гарсан авлага байна.

Бараа материалын дансны оны эцсийн үлдэгдэл 136.9 сая төгрөг болж 34.6 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 141.6 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, БШУЯам болон Орон нутгийн хөгжлийн сангаас 21.5 сая төгрөгийн аж ахуйн материал, Боловсролын газраас 4.2 сая төгрөгийн ном сурах бичгийг төлбөргүй бүгд бүгд 167.3 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч данс бүртгэлд тусгаж, 132.7 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны оны эцсийн үлдэгдэл 5558.7 сая төгрөг болж 1579.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 33.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, өмнөх онд “Саммит компьютер технологи” ХХК-аас цахим худалдан авалтаар нийлүүлээгүй 8.7 сая төгрөгийн авлагыг барагдуулж нийт 42.1 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг худалдан авч, Олон улсын хүмүүнлэгийн байгууллагаас 38.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1499.3 сая төгрөгийн дотуур байрын барилга болон тавилга тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 1549.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт дансаар ямар нэгэн гүйлгээ орж гараагүй байна.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1478.5 сая, нийт зарлагыг 1478.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Улсын төсвийн төслийн саналаас зардлыг 1292.6 зардлыг сая төгрөгөөр бууруулж 2771.1 сая төгрөгөөр баталсан байна.

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны анх батлагдсан төсөв 1295.0 сая төгрөг ба тодотгосон төсөв 2771.1 сая төгрөг болж анх баталснаас 1476.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор 4 дүгээр сараас төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2475.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 293.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1.8 сая төгрөг бүрдүүлж бүгд 2771.1 сая төгрөгийн орлого санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2475.8 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 267.6 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1.8 сая төгрөг бүрдүүлж бүгд 2645.6 сая төгрөгийн орлого санхүүжилтээр үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн зарлагын нийт гүйцэтгэл 2615.7 сая төгрөг буюу 94.4 хувьтай буюу дансанд 127.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Нийт төсвийн зарлагын 82.4 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 2.2 хувийг норматив зардал, 10.2 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 0.8 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 2.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 1.8 хувийг бусад урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 52.6 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 7.1 сая төгрөгөөр, норматив зардлыг 31.5 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 25.8 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 8.4 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 21.6 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 8.1 сая төгрөгөөр бүгд 155.3 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
71802	Ерөнхий боловсрол	2,251.2	-	2,251.2	-
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	3,119.4	3,055.5	63.9	98.0
80233	Хүүхэд хамгаалал	3,315.6	3,208.0	107.6	96.8
80312	Сургалт семинар	2,703.1	1,312.7	1,390.4	48.6
81605	Эрүүл мэндийг дэмжих	3,069.8	750.0	2,319.8	24.4
81801	үдийн цай хөтөлбөр	53,611.1	45,485.4	8,125.7	84.8

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

81806	Дотуур байрны үйлчилгээ	354,761.1	322,420.6	32,340.5	90.9
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	31,800.0	31,800.0	-	100.0
81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	9,717.4	-	9,717.4	-
81827	Бичиг үсгийн боловсролын хөтл	25,549.8	25,404.6	145.2	99.4
81834	Боловсролын стандарт, сургалты	1,902,062.1	1,833,244.3	68,817.8	96.4
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	81,403.0	81,403.0		100.0
81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	4,258.8	-		-
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	293,430.0	267,651.9		91.2
<b>Дүн</b>		<b>2,771,052.40</b>	<b>2,615,735.97</b>	<b>125,279.53</b>	<b>94.4</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн тайлангийн аудитын ерөнхий бодлого чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Тус сургууль нь Ахмадын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан ажиллуулах журам”-ыг хэргжүүлээгүй буюу ахмадын сах байгуулж ажиллаагүй байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж ажиллаагүй байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 20.3 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын дансаар 56.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулан авч хянаж үзэхэд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр тушаалаар баталсан төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны жишиг орон тоонд заасны дагуу 14 байх ёстойгоос 1 орон тоо буюу эмчийн орон тоог илүү баталж ажиллуулж ирсэн байна.

Тус сургуулийн 1-12 дугаар сарын цалин олгох хүснэгтээр 80-83 хүнд цалин хөлс олгосон байна. Аймгийн Засаг даргын захирамжаар 81 орон тоо батлагдсанаас 83 хүн ажиллаж 2 орон тоо илүү байна. Энэ нь насан туршийн боловсрол хариуцсан багш, бага ангийн багшийн 1 орон тоо батлагдаагүй боловч сул орон тоонд зохицуулан ажиллуулж ирсэнтэй холбоотой байна.

Боловсролын үнэлгээний төвөөс ирүүлсэн багш болон байгууллагын үнэлгээний дагуу индексийн 1-4 дүгээр түвшнээс доош үнэлэгдсэн 31 багшид 2024 оны 3 сарын урамшуулалт цалинг зохих журмын дагуу олгосон байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Сургууль нь 2024 онд батлагдсан төсвийн хүрээнд “Монголын цахилгаан холбоо” ХХК-31.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг цахим худалдан авалтаар худалдан авч данс бүртгэлд тусгасан байна.

## **АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 35,594.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 26.7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар 29 арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд алдаа зөрчил илрээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулах 2768.8 сая төгрөгийн 159 мэдээллийг хугацаанд байршуулсан ба 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Таван сая төгрөгөөс дээш мөнгөн дүнтэй нийтдээ 11 гүйлгээ буюу 288.5 сая төгрөгийн гүйлгээг бүрэн байршуулсан. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувь байна. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэрийг байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 2.8 сая төгрөгийн зөрчил арилгуулах 1 албан шаардлага хүргүүлсэн. Албан шаарлагын биелэлтийг давтан шалгаж үзэхэд 28.1 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	2849.5	1	800.0	28.1%
Нийт дүн	1	2849.5	1	800.0	28.1%

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар хөрөнгийн тооллоготой холбоотой асуудлыг анхаарах шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 27,566.1 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрч 27,566.1 мянган төгрөгийн алдааг залруулсан.Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайланд төсөвт төвлөрүүлсэн 25,778.1 мянган төгрөгийг, номын түрээсийн орлого 1,788.0 мянган төгрөгийг тайлант оны гүйцэтгэлийн эх үүсвэр, зарлагад тус тус илүү тайлагнасныг залруулав

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй

### 5.2 Албан шаардлага

1. Сургуулийн захирлын 2024 оны 11 дугаар сарын 27-ны өдрийн “Балансын урамшуулал олгох тухай” А/35 дүгээр тушаалаар нягтлан бодогчид 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэж 1400.0 мянган төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллыг холбогдох хууль, журам зөрчиж тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

##### 1.1 Илрүүлэлт:

Сургууль нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /дотуур байрны хоол хүнс 58.4 сая төгрөг, үдийн хоол 45.5 сая төгрөг, худалдан авсан үндсэн хөрөнгө 33.5 сая төгрөг г.м/ сарын төсвийн хуваарийн дагуу шууд худалдан авалт хийсэн байна.

##### 1.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТГТайлан зөрүүтэй тайлагнасан	1	25778.1					1	25778.1				
ТГТайлан зөрүүтэй тайлагнасан	1	1788.0					1	1788.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>27566.1</b>					<b>2</b>	<b>27566.1</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хууль журам зөрчиж олгосон	1	1400.0			1	1400.0						
Худалан авалттай холбоотой	1						1					
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1400.0</b>			<b>1</b>	<b>1400.0</b>	<b>1</b>					

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан